



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/060/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2025 оны 02 дугаар сарын 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/53

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020292

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 5 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 91.4 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>167,740,569.37</u>	<u>301,184,434.81</u>
33	АВЛАГА	57,732,001.37	164,625,531.81
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	106,960,072.00
335	Бусад авлага	57,732,001.37	57,665,459.81
3351	Байгууллагаас авах авлага	57,732,001.37	57,665,459.81
35	БАРАА МАТЕРИАЛ	110,008,568.00	136,558,903.00
351	Түүхий эд материал	6,852,333.00	4,206,018.00
35110	Тусгай зориулалттай материал	6,852,333.00	4,206,018.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,926,400.00	53,820,000.00
354	Хангамжийн материал	54,201,000.00	50,324,050.00
35410	Бичиг хэргийн материал	200,000.00	200,000.00
35420	Аж ахуйн материал	32,809,600.00	33,450,650.00
35430	Сэлбэг хэрэгсэл	21,191,400.00	16,673,400.00
35600	Мал амьтад	36,028,835.00	28,208,835.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,221,081,641.18</u>	<u>1,549,870,033.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,221,081,641.18	1,549,870,033.58
392	Биет хөрөнгө	1,201,702,099.41	1,531,507,366.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,284,759,337.51	1,450,569,357.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-432,302,272.53	-454,329,550.31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,232,015.30	312,898,681.97
39204	Хуримтлагдсан элэгдэл	-198,459,723.64	-203,698,293.09
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	408,376,555.98	556,066,287.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	-214,768,075.48	-261,287,974.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,446,955.00	70,446,955.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51,164,420.92	-53,788,124.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	146,424,914.19	146,424,914.19
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,972,986.00	-33,924,686.82
39217	Ном	2,129,800.00	2,129,800.00
393	Биет бус хөрөнгө	19,379,541.77	18,362,666.79
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-662,500.00	-750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	29,501,000.00	29,501,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-10,208,958.23	-11,138,333.21
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,388,822,210.55</u>	<u>1,851,054,468.39</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,542.44</u>	<u>311,766.66</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,542.44	311,766.66
413	Өглөг	6,542.44	311,766.66
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	311,766.66
4136	Бусад өглөг	6,542.44	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,542.44	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,388,815,668.11</u>	<u>1,850,742,701.73</u>

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	1,388,815,668.11	1,850,742,701.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	525,196,220.52	525,196,220.52
51101	Өмч: - төрийн	525,196,220.52	525,196,220.52
512	Хуримтлагдсан үр дүн	317,948,907.40	779,875,941.02
51210	Өмнөх үеийн үр дүн	317,948,907.40	317,948,907.40
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	461,927,033.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	545,670,540.19	545,670,540.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,388,822,210.55</u>	<u>1,851,054,468.39</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	974,103,613.00	1,744,261,575.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,368,460.00	543,436,907.90
120	Нийтлэг татварын бус орлого	117,368,460.00	543,436,907.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	117,368,460.00	543,436,907.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /УХ/	52,433,225.00	391,858,417.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/	64,935,235.00	151,578,490.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	856,735,153.00	1,200,824,667.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,044,344,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,044,344,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,367,753.00	156,479,767.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	107,367,753.00	156,479,767.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	749,367,400.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	749,367,400.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	854,227,475.12	1,282,334,541.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,227,475.12	1,282,334,541.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,482,992.08	1,204,769,383.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	383,444,765.24	624,688,687.34
210101	Үндсэн цалин	279,776,759.34	380,577,424.75
210102	Нэмэгдэл	86,373,494.26	221,009,062.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,409,000.00	11,570,000.00
210104	Урамшуулал	9,885,511.64	11,532,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,077,400.00	78,231,118.51
210201	Тэтгэврийн даатгал	32,733,009.23	52,975,051.57
210202	Тэтгэмжийн даатгал	3,850,942.19	6,241,326.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,067,553.82	3,411,424.04
210204	Ажилгүйдлийн даатгал	757,010.21	3,120,663.28
210205	Эрүүл мэндийн даатгал	7,668,884.55	12,482,653.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,050,807.69	70,778,569.40
210301	Гэрэл, цахилгаан	10,518,141.69	13,153,233.40

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	32,504,666.00	57,625,336.00
210303	Цэвэр, бохир ус	28,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,524,869.00	54,272,562.37
210401	Бичиг хэрэг	13,341,050.00	3,733,800.00
210402	Тээвэр, шатахуун	40,743,116.00	22,575,812.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	566,000.00	890,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,734,703.00	26,105,165.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,140,000.00	967,785.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00	2,950,000.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	2,950,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,704,000.00	5,556,000.00
210702	Дотоод албан томилолт	5,704,000.00	5,556,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-37,777,879.00	186,358,920.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-44,957,580.00	182,076,170.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	799,525.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,196,352.00	99,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	136,250.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	483,574.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,959,029.15	181,933,525.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,785,080.00	98,055,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,695,250.00	1,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	93,478,699.15	82,378,025.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,744,483.04	77,565,158.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,950,000.00	1,306,250.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	445,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,505,000.00	1,306,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	131,794,483.04	76,258,908.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	131,794,483.04	76,258,908.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>119,876,137.88</u>	<u>461,927,033.62</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>119,876,137.88</u>	<u>461,927,033.62</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>856,735,153.00</u>	<u>1,200,824,667.50</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	856,735,153.00	1,200,824,667.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,044,344,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,044,344,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,367,753.00	156,479,767.50

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	107,367,753.00	156,479,767.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	749,367,400.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	749,367,400.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	803,722,623.00	1,181,516,667.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	803,722,623.00	1,181,516,667.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,978,139.96	958,867,297.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,280,612.27	626,920,661.44
210101	Үндсэн цалин	241,433,271.50	357,534,810.26
210102	Нэмэгдэл	123,824,421.77	243,882,226.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,379,000.00	10,723,290.64
210104	Урамшуулал	780,000.00	14,780,333.93
210105	Гэрээт ажлын хөлс	12,863,919.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,909,600.00	75,547,700.00
210201	Тэтгэврийн даатгал	31,833,500.00	51,372,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,536,800.00	6,043,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,697,100.00	3,021,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	803,800.00	3,021,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,038,400.00	12,087,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,053,807.69	70,778,569.40
210301	Гэрэл, цахилгаан	10,518,141.69	13,153,233.40
210302	Түлш, халаалт	32,507,666.00	57,625,336.00
210303	Цэвэр, бохир ус	28,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,858,313.00	54,720,561.00
210401	Бичиг хэрэг	5,860,550.00	3,632,800.00
210402	Тээвэр, шатахуун	21,746,660.00	23,311,662.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,278,000.00	890,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,833,103.00	26,046,099.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,140,000.00	840,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,100,000.00	2,950,000.00
210604	Урсгал засвар	4,100,000.00	2,950,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,676,000.00	5,556,000.00
210702	Дотоод албан томилолт	5,676,000.00	5,556,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,398,327.00	15,882,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,221,626.00	11,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	799,525.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,193,352.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	136,250.00	99,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210807	Газрын төлбөр	483,574.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,701,480.00	106,511,056.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,729,730.00	105,011,056.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,971,750.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,744,483.04	222,649,369.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,950,000.00	39,430,389.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	360,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	38,124,139.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,590,000.00	1,306,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	131,794,483.04	183,218,980.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	131,794,483.04	183,218,980.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>53,012,530.00</u>	<u>19,308,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	53,012,530.00	19,308,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	53,012,530.00	19,308,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	53,012,530.00	19,308,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	53,012,530.00	19,308,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-53,012,530.00</u>	<u>-19,308,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	514,730,220.52	250,998,634.30	6,477,380.78	00.00	772,206,235.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	514,730,220.52	250,998,634.30	6,477,380.78	00.00	772,206,235.60
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-31,193,963.26	00.00	-31,193,963.26
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	545,670,540.19	317,948,907.40	00.00	1,388,815,668.11
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	545,670,540.19	317,948,907.40	00.00	1,388,815,668.11
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	525,196,220.52	545,670,540.19	317,948,907.40	00.00	1,388,815,668.11
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	461,927,033.62	00.00	461,927,033.62
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	545,670,540.19	779,875,941.02	00.00	1,850,742,701.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,045,344,900.00	968,085,991.84	77,258,908.16	92.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,045,344,900.00	968,085,991.84	77,258,908.16	92.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,043,944,900.00	966,779,741.84	77,165,158.16	92.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	629,256,200.00	626,920,661.44	2,335,538.56	99.6
210101	Үндсэн цалин	366,619,900.00	357,534,810.26	9,085,089.74	97.5
210102	Нэмэгдэл	242,131,700.00	243,882,226.61	-1,750,526.61	100.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,504,600.00	10,723,290.64	9,781,309.36	52.3
210104	Урамшуулал	-	14,780,333.93	-14,780,333.93	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,547,700.00	75,547,700.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	51,372,500.00	51,372,500.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,043,800.00	6,043,800.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,021,900.00	3,021,900.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,021,900.00	3,021,900.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,087,600.00	12,087,600.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,947,800.00	70,778,569.40	3,169,230.60	95.7
210301	Гэрэл, цахилгаан	14,708,200.00	13,153,233.40	1,554,966.60	89.4
210302	Түлш, халаалт	58,739,600.00	57,625,336.00	1,114,264.00	98.1
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	-	500,000.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	55,365,000.00	55,028,561.00	336,439.00	99.4
210401	Бичиг хэрэг	3,645,200.00	3,632,800.00	12,400.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	23,323,300.00	23,311,662.00	11,638.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,268,500.00	1,198,000.00	70,500.00	94.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	26,288,000.00	26,046,099.00	241,901.00	99.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	840,000.00	840,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00	15,950,000.00	50,000.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,950,000.00	50,000.00	98.3
2107	Томилолт, зочны зардал	5,645,200.00	5,556,000.00	89,200.00	98.4
210702	Дотоод албан томилолт	5,645,200.00	5,556,000.00	89,200.00	98.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	10,222,000.00	9,782,750.00	439,250.00	95.7

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	119,250.00	60,750.00	66.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18,000.00	-	18,000.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	160,000.00	99,500.00	60,500.00	62.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	-	300,000.00	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	177,961,000.00	107,215,500.00	70,745,500.00	60.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176,461,000.00	105,715,500.00	70,745,500.00	59.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,400,000.00	1,306,250.00	93,750.00	93.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.00	1,306,250.00	93,750.00	93.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,306,250.00	93,750.00	93.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,045,344,900.00	1,044,344,900.00	1,000,000.00	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,044,344,900.00	968,085,991.84	76,258,908.16	92.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,044,344,900.00	968,085,991.84	76,258,908.16	92.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	-	1,000,000.00	0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	-	1,000,000.00	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.0

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	156,479,767.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,479,767.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,395,556.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,100,000.00

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,295,556.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,295,556.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,124,139.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,124,139.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,124,139.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	106,960,072.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	106,960,072.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	156,479,767.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	156,479,767.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	156,479,767.50
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хэрэгжүүлэн ажилладаг сумын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах чиг үүрэгтэй ажилладаг.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ нь орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологи нэвтэрсэн өндөр мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчний чадварт түшиглэн төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгын хүрээнд тайлант онд дараах 5 зорилт 63 арга хэмжээг хэрэгжүүлэн санхүү алба, хөдөө аж ахуйн тасаг, байгаль орчны алба, захиргаа аж ахуй 4 албатай 23 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга Ц.Мөнхжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Баттулга нар зурж, нярваар Ж.Мөнхжаргал нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол



- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандартын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,744,094.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 355,272.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	167,740.6	194,224.4	26,483.8

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Авлага	57,732.0	57,665.5	(66.5)
Бараа материал	110,008.6	136,558.9	26,550.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,221,081.6	1,549,870.0	411,166.4
Үндсэн хөрөнгө	2,157,620.6	2,568,787.0	411,166.4
Хуримтлагдсан элэгдэл	(936,538.9)	(1,018,917.0)	(82,378.1)
Нийт хөрөнгө	1,388,822.2	1,744,094.4	355,272.1
Өр төлбөр	6.5	311.8	305.3
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	1,388,815.7	1,743,782.6	354,966.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,388,822.2	1,744,094.4	355,272.1

Дээрх хүснэгтээс харахад, авлага дансны үлдэгдэл 57,665.5 мянган төгрөг байгаа нь моторын авлага 57,600.0 мянга, ХХОАТ-ын 65.5 мянган төгрөгийн авлагыг тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 136,558.9 мянган төгрөг болж өмнөх оноос 26,550.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 280,932.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар төсвийн байгууллагаас 1,700.3 мянга, бусад байгууллагаас 10,508.2 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 266,591.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,568,787.0 мянган төгрөг болж 411,166.4 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 116,974.7 мянга, хандиваар ирсэн 154,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж, 139,591.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 311.8 мянган төгрөг байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн 311.8 мянган төгрөгийн өглөгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 354,966.9 мянган төгрөгөөр өсөж 1,743,782.6 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 846,331.8 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,800.0 мянга нийт 848,131.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэх, нийт зарлагыг 848,131.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2 удаа тодотгол хийж орон нутгийн төсвөөс 1,044,344.9 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянга нийт 1,045,344.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,044,344.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,044,344.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөг оруулахаар төвлөсөн ба орлого төвлөрөөгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 968,086.1 мянган төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 76,258.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсөв					
1	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,044,344.9	968,086.0	76,258.7	92.7
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	709,465.2	705,487.5	3,977.7	99.4
1.2	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	131,970.7	130,743.7	1,227.0	99.1
1.3	80112 Нийтлэг үйлчилгээ	1,000.0	931.3	68.7	93.1
1.4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	66,461.0	66,455.5	5.5	100.0
1.5	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	110,000.0	39,260.0	70,740.0	35.7
1.6	82212 Хур хог хаягдал орчны бохирдлыг устгах зардал	25,448.0	25,208.1	239.9	99.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 3,977.7 мянга буюу 0.6 хувь, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 1,227.0 мянга буюу 0.9 хувь, нийтлэг үйлчилгээний зардлыг 68.7 мянга буюу 6.9 хувь, орон нутгийн нөөц хөрөнгөөс 5.5 мянга, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 70,740.0 мянга буюу 64.3 хувь, хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зардлаас 239.9 мянга буюу 0.9 хувь нийт 76,258.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 156,479.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 38,124.1 мянга, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, шилжүүлэг 106,960.1 мянга, бараа үйлчилгээний бусад

зардалд 5,295.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 6,100.0 мянга, нийт 156,479.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсөв 1,045,344.9 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 854,500.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,453.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 6,794.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,076,492.6 мянган төгрөгийн 43 гүйлгээ, зарлагын 327,729.6 мянган төгрөгийн 22 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны 12 сард эхний 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийж шилэн дансны цахим сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 113,124.1 мянган төгрөгийн 4 гүйлгээ мэдээлээгүйг нөхөн мэдээлүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 43,328.1 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 30,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, зөрчлийг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх 9,867.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага тогтоож, 3,461.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	3,461.9	2	3,461.9	100
Албан шаардлага	2	9,867.1	2	9,867.1	100
Зөвлөмж	2	30,000.0	2	30,000.0	100
Нийт дүн	6	43,328.1	6	43,328.1	100



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/151 дүгээр захирамжаар тус байгууллагын түлш халаалтын зардлаас хэмнэгдсэн 12,842.3 мянган төгрөгийг ЕБС-ын халаалтын зардалд 8,842.3 мянга, цэцэрлэгийн халаалтын зардалд 4,000.0 мянган төгрөгийг сумын ИТХ-аар хэлэлцэхгүйгээр шийдвэрлэн санхүүжилтийг бууруулсан асуудлыг Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитаар авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 190,166.7 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан 92,500.0 мянган төгрөг өвс, тэжээл, 46,266.7 мянган төгрөгийн трактор, 51,400.0 мянган төгрөгийн хог тээврийн авто машиныг шилжүүлэн авсан байхад төсвийн хөрөнгөөр худалдан авсан гэж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 4,672.1 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс, 172.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 4,672.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 6,794.7 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 2,1211.6 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тэтгэвэрт гарсан албан хаагчийн цалинг НДШ-ийн мэдээнд 2024 оны 6 дугаар сард 717.1 мянган төгрөгөөр илүү мэдээлснээс 172.1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлсэн 172.1 мянган төгрөгийг дарга, нягтлан бодогч нараар төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. “Дурсамж принт” ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 2021 онд үйлдвэрлэсэн өмнөх онд өглөгөөр тусгаагүй “Өрхтэй харилцах дэвтрийн үнэ”-д 4,500.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид санхүүгийн тайланд тусгагдаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй гүйлгээ хийхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд хөрөнгийг буруу ангиллаар бүртгэсэн	1	190,166.7	-	-	1	190,166.7	1	190,166.7	-	-
Дүн	1	190,166.7	-	-	1	190,166.7	1	190,166.7	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэтгэвэрт гарсан албан хаагчийн цалинг НДШ-ийн мэдээнд 2024 оны 6 дугаар сард 717.1 мянган төгрөгөөр илүү мэдээлснээс 172.1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.	1	172.1	1	172.1	-	-	-	-
"Дурсамж принт" ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 2021 онд үйлдвэрлэсэн өмнөх онд өглөгөөр тусгаагүй "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ"-д 4,500.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн байна.	1	4,500.0	-	-	1	4,500.0	-	-
Дүн	2	4,672.1	1	172.1	1	4,500.0	-	-

-----oO-----

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/151 дүгээр захирамжаар тус байгууллагын түлш халаалтын зардлаас хэмнэгдсэн 12,842.3 мянган төгрөгийг ЕБС-ын халаалтын зардалд 8,842.3 мянга, цэцэрлэгийн халаалтын зардалд 4,000.0 мянган төгрөгийг сумын ИТХ-аар хэлэлцэхгүйгээр шийдвэрлэн санхүүжилтийг бууруулсан асуудлыг Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитаар авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 297,126.8 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан 92,500.0 мянган төгрөг өвс, тэжээл, 46,266.7 мянган төгрөгийн трактор, 51,400.0 мянган төгрөгийн хог тээврийн авто машиныг шилжүүлэн авсан байхад төсвийн хөрөнгөөр худалдан авсан гэж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 106,960.1 мянган төгрөгийн орлогыг авлагаар тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 4,672.1 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс, 172.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 4,672.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 6,794.7 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 2,1211.6 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тэтгэвэрт гарсан албан хаагчийн цалинг НДШ-ийн мэдээнд 2024 оны 6 дугаар сард 717.1 мянган төгрөгөөр илүү мэдээлснээс 172.1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлсэн 172.1 мянган төгрөгийг дарга, нягтлан бодогч нараар төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. “Дурсамж принт” ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 2021 онд үйлдвэрлэсэн өмнөх онд өглөгөөр тусгаагүй “Өрхтэй харилцах дэвтрийн үнэ”-д 4,500.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид санхүүгийн тайланд тусгаадаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй гүйлгээ хийхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд хөрөнгийг буруу ангиллаар бүртгэсэн	1	190,166.7	-	-	1	190,166.7	1	190,166.7	-	-
Санхүүгийн тайланд авлагыг тусгалгүй орхигдуулсан	1	106,960.1	1	106,960.1	-	-	1	106,960.1	-	-
Дүн	2	297,126.8	1	106,960.1	1	190,166.7	2	297,126.8	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэтгэвэрт гарсан албан хаагчийн цалинг НДШ-ийн мэдээнд 2024 оны 6 дугаар сард 717.1 мянган төгрөгөөр илүү мэдээлснээс 172.1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.	1	172.1	1	172.1	-	-	-	-
"Дурсамж принт" ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 2021 онд үйлдвэрлэсэн өмнөх онд өглөгөөр тусгаагүй "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ"-д 4,500.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн байна.	1	4,500.0	-	-	1	4,500.0	-	-
Дүн	2	4,672.1	1	172.1	1	4,500.0	-	-

-----oO-----